



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/284

Зуунмод


Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн  
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл  
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3.5, 19.20.5 дугаар заалтууд, аймгийн “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ын 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн нэгдүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эмийн сангийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын нэрийг нэгдүгээр, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, стандарт мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 16 өдрийн  
A/284 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ  
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр, байршил	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	“Өөгөө фарм” ХХК-ийн “Өөгөө фарм” эмийн сан /Баяндэлгэр сум/	Эмийн сангийн үйл ажиллагаа	3 жил

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 16 өдрийн  
A/284 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ  
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	“Хаан мэлз” ХХК-ийн “Гурван хонгор” сувилал /Баяндэлгэр сум/	Сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа
2	Лувсангомбо Хадбаатар /Зуунмод сум/	Ахуйн мэрэгч, шавьж устгах, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа

оОо